

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МАТЕРИАЛ

2025.04.29-ний 10:00 ЦАГТ

“БидиСЕК ҮЦК” ХК-ийн
<https://agm.mn/> цахим
системээр зохион
байгуулна.

Лавлах утас:

90999494, 80498649
etranslogistics@hotmail.com



АГУУЛГА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ШИЙДВЭР, ХАВСРАЛТУУД

Хэлэлцэх асуудал 1.

Компанийн 2024 оны санхүүгийн тайлан түүнд хийсэн хараат бус аудитын дүгнэлт;

Хэлэлцэх асуудал 2.

Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлагнал;

Хэлэлцэх асуудал 3.

Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаар төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт;

Хэлэлцэх асуудал 4.

Компанийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө;

Хэлэлцэх асуудал 5.

ТУЗ-ийн 2025 оны цалин урамшууллын төсөв;

Хэлэлцэх асуудал 6.

ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчид;

Хэлэлцэх асуудал 7.

Ногдол ашгийн талаар гаргасан шийдвэр танилцуулах;

Тэмдэглэл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ШИЙДВЭР, ХАВСРАЛТУУД;



Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025. 05. 18.

№ 02.

Борхойн тал

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60-р зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам", "Э-ТРАНС ЛОЖИСТИКС" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн эчнээ хурлын саналыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. "Э-Транс ложистикс" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 сарын 29-ний өдрийн 10 цагт "БиДиСек ҮЦК" ХК-ийн <https://agm.mn/> цахим системээр хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - a. Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
 - b. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан
 - c. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах
 - d. Компанийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 - e. ТУЗ-ийн 2025 оны цалин урамшууллын төсөв батлах
 - f. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
 - g. Ногдол ашгийн талаарх шийдвэрийг танилцуулах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг "Хурал хуралдуулах тухай зар"-ийг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 18 дах өдөр буюу 2025 оны 04 сарын 08-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Хавсралт №1-ийн дагуу баталж, нийтэд мэдээлэх өдрийг ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш 3 дахь өдөр буюу 2025 оны 03 сарын 20-ний өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын сониноор мэдээлэх, хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2025 оны 04 сарын 04-ний өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт №2-оор баталсугай.


6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №3-р баталсугай. Хавсралт №3-д заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд "БиДиСек ҮЦК" ХК-ийн төв оффис, компанийн цахим хуудас, Facebook дэх пэйж болон хурлын зар дахь цахим хаяг, утсаар хурал зохион байгуулах комиссын дарга С.Ганбат, Г.Энхжин нараас авч танилцах боломжтой.
7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах "Саналын хуудас"-ийн агуулгыг Хавсралт №4-ийн дагуу баталсугай .
8. Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс "Санал авах хуудас"-ийг хүлээн авах сүүлийн өдрийг хурал хуралдах өдөр буюу 2025 оны 04 сарын 29-ний 10:00 цаг хүртэл байхаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Э.Батболд, хурал зохион байгуулах комиссын даргаар С.Ганбат, гишүүнээр Б.Золзаяа, тооллогын комиссын даргаар С.Дөлгөөн, гишүүнээр М.Мишээл, Г.Энхжин нарыг тус тус томилсугай.
- 10.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.
- 11.ХЭХ хуралдуулах ажлыг холбогдох хууль журмын дагуу гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал Ч.Энхболдод үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Э.БАТБОЛД

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025
оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
№02 тоот тогтоолын "Хавсралт №1"



“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг Төмөр замын өргөн чөлөөний гудамж, 04-411-т байрлах “Э-Транс Ложистикс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 сарын 29-ний өдөр 10:00 цагт болно.

Хурал зохион байгуулах газрын хаяг: “ БиДиСЕК ҮЦК “ ХК-ийн <https://agm.mn/> цахим системээр

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр:

2025 оны 04-р сарын 08-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан
3. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах
4. Компанийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
5. ТУЗ-ийн 2025 оны цалин урамшууллын төсөв батлах
6. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
7. Ногдол ашгийн талаар гаргасан шийдвэрийг танилцуулах

Хурлын материал, гарах шийдвэрийн төсөл болон холбогдох баримт бичигтэй ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн төв оффис, компанийн цахим хуудас, Facebook дэх пэйж хуудас болон доорх цахим хаяг, утсаар хурал зохион байгуулах комиссын дарга С.Ганбатаас холбогдох мэдээллийг авч танилцах боломжтой.

Холбоо барих: 90999494, 80498649

И-мэйл хаяг: etranslogistics999@gmail.com, etranslogistics@hotmail.com

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025
оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
№02 тоот тогтоолын "Хавсралт №2"



**"Э-ТРАНС ЛОЖИСТИКС" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

Хурал 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 10:00 цагт эхэлнэ.

1	Хурлын ирцийг бүртгэх (ажлын хэсэг)	10:00-10:10
2	Хурлын ирцийг мэдээлэх (ажлын хэсэг)	10:10-10:15
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	10:15-10:25
4	Хурлаар хэлэлцэх асуудлууд	
	Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт	10:25-10:35
	Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан	10:35-10:45
	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах	10:45-10:55
	Компанийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах	10:55-11:05
	ТУЗ-ийн 2025 оны цалин урамшууллын төсөв батлах	11:05-11:15
	ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох	11:15-11:20
	Ногдол ашгийн талаар гаргасан шийдвэрийг танилцуулах	11:20-11:25
5	Асуулт хариулт	11:25-11:35
6	Саналын хуудас бөглөх заавар өгөх	11:35-11:40
7	Санал хураалт	11:40-11:55
8	Хурлын завсарлага	11:55-12:00
9	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	12:00-12:05
10	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	12:05-12:15
11	Хурлыг хаах (хурлын дарга)	12:15-12:20

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025
оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
№02 тоот тогтоолын "Хавсралт №3"



**"Э-ТРАНС ЛОЖИСТИК" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТАНИЛЦАЖ БОЛОХ
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт;
2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан;
3. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайлан;
4. Компанийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө;
5. ТУЗ-ийн 2025 оны цалин урамшууллын төсөв;
6. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийн танилцуулга;
7. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ын шийдвэр;

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн №02 тоот тогтоолын "Хавсралт №4"



"Э-ТРАНС ЛОЖИСТИК" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овогнэр.....

Регистерийн дугаар

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн Тоо:

Бүртгэсэн / Үнэт цаасны компани /

Брокерийн овог: нэр:

"Э-ТРАНС ЛОЖИСТИК" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 10 цагт "БидиСек ҮЦК" ХК-ийн <https://agt.mn/> цахим системээр зохион байгуулах болно.

Дараах хэлэлцэх асуудлуудад **ЕРДИЙН АРГААР** санал хураана.
Саналын хуудас бөглөх заавар: Ердийн журмаар саналаа өгөхөд асуудал бүрээр "зөвшөөрсөн", "татгалзсан", "түдгэлзсэн" аль нь болгохыг ✓ тэмдэглэж санал болгоны ард гарын үсгээ зурна.

№	ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал	Гарын үсэг
1.	2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах;	Тогтоол №_	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
2.	Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг батлах	Тогтоол №_	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
3.	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах	Тогтоол №_	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
4.	2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах	Тогтоол №_	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
5.	ТУЗ-ийн 2025 оны цалин урамшууллын төсөв батлах	Тогтоол №_	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		


Саналын хуудас хүлээн авсан: Брокер /
2025 оны ____ сарын ____ /

Хэлэлцэх асуудал №,, саналыг хүчинтэйд тооцов.

Тооллогын комиссын дарга:..... / С.Дөлгөөн /
Тооллогын комиссын гишүүн:..... / Г.Энжин /
Тооллогын комиссын гишүүн:..... / М.Мишээл /

Хэлэлцэх асуудал №,, саналыг хүчингүйд тооцсон шалтгаан:
.....

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025
оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
№02 тоот тогтоолын "Хавсралт №4"



**"Э-ТРАНС ЛОЖИСТИК" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог нэр.....

Регистерийн дугаар

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн Тоо:

Бүртгэсэн / Үнэт цаасны компани /

Брокерийн овог: нэр:

Э-ТРАНС ЛОЖИСТИК" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 10 цагт " БидСек ҮЦК " ХК-ийн <https://egm.mn/> цахим системээр зохион байгуулагдана.

Дараах хэлэлцэх асуудалд КУМУЛЯТИВ АРГААР санал хураана.

Саналын хуудас бөглөх заавар: "Э-Транс Ложистик" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь ердийн 6 гишүүн, хараат бус 3 гишүүнтэй байна.

Кумулятив саналын тоо нь таны эзэмшиж байгаа энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүдсэнтэй тэнцүү байна.

Жишээ нь: Та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл нийт 100*9=900 кумулятив саналын эрхтэй болно. Та нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг эсвэл хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.

6. ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох		
ЕРДИЙН ГИШҮҮДЭД НЭР ДЭВШИГЧИД	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1	Тогтоол №	
2	Тогтоол №	
3	Тогтоол №	
4	Тогтоол №	
5	Тогтоол №	
6	Тогтоол №	
ХАРААТ БУС ГИШҮҮДЭД НЭР ДЭВШИГЧИД	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
7	Тогтоол №	
8	Тогтоол №	
9	Тогтоол №	

Санал өгсөн хувьцаа эзэмшигч: / /

Саналын хуудас хүлээн авсан брокер / /

2025 оны ____ сарын ____

Саналын хуудсыг хүчинтэйд тооцсон

тооллогын комиссын дарга: / С.Дөлгөөн /

Тооллогын комиссын гишүүн: / Г.Энхжин /

Тооллогын комиссын гишүүн: / М.Мишээл /

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон шалтгаан:

.....

САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцох боломжгүй тохиолдолд харилцагч брокерын компаниараа дамжуулан хурлын материалтай танилцан саналын хуудсаа өгөх боломжтой.
2. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
3. **Ердийн аргаар** өгөх санал хураалтад хэлэлцэх асуудал тус бүр дээр нэгээс олон тэмдэглэгээ хийсэн тохиолдолд санал хүчингүйд тооцогдоно.
4. Гарын үсгээ зураагүй санал хүчингүйд тооцогдоно.
5. Итгэмжлэлээр санал өгч буй итгэмжлэгдсэн төлөөлөгч нь итгэмжлэл дээрх өөрийн баталгаат гарын үсгийг зурснаар санал хүчинтэйд тооцогдоно.
6. Насанд хүрээгүй хувьцаа эзэмшигчийн асран хамгаалагч нь хүүхдийнхээ бус өөрийнхөө гарын үсгийг зурснаар санал хүчинтэйд тооцогдоно.
7. **Кумулятив аргаар** ТУЗ-д нэр дэвшигчдэд өгсөн нийт саналын тоо кумулятив саналын тооноос зөрсөн тохиолдолд саналын хуудсыг хүчингүйд тооцно.
8. Гарын үсэггүй санал хүчингүйд тооцогдоно.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 1. КОМПАНИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТҮҮНД ХИЙГДСЭН ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТ

1.1 САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН / АУДИТЛАГДААГҮЙ ТАЙЛАН /

Компанийн санхүүгийн байдалд хараат бус аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулахаар ажиллаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар энэхүү дүгнэлт гараагүй байгаа тул аудит хийгдээгүй санхүүгийн тайланг оруулж байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах болно.

	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ХӨРӨНГӨ		
Мөнгөн хөрөнгө	571,517,003.97	1,688,511,269.25
Дансны авлага	17,495,784.15	1,734,727,718.13
Татвар, НДШ - ийн авлага	0.00	0.00
Бусад авлага	4,000,000.00	5,811,291.00
Бараа материал	56,790,945.38	30,931,295.18
Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	296,947,443.64	837,821,954.27
Эргэлтийн хөрөнгийн дүн	946,751,177.14	4,297,803,527.83
Үндсэн хөрөнгө	4,409,230,682.53	4,649,637,784.59
Биет бус хөрөнгө	280,699,288.96	278,907,691.84
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,689,929,971.48	4,928,545,476.42
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,636,681,148.62	9,226,349,004.25
Дансны өглөг	1,284,676.76	1,284,676.76
Татварын өр	80,215,714.35	134,468,186.16
Урьдчилж олсон орлого	3,400,000.00	0.00
Бусад богино хугацаат өр төлбөр	11,508,006.80	12,717,580.80
Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	3,139,341,571.66
Богино хугацаат өр төлбөрийн дүн	101,331,003.22	148,470,444.01
Урт хугацаат зээл	0.00	3,139,341,571.66
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	101,331,003.22	3,287,812,015.67

Эзэмшигчдийн өмч		
- хувийн	4,620,000,000.13	4,620,000,000.13
Нэмж төлөгдсөн капитал	154,000,000.00	154,000,000.00
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	774,858,080.00	774,858,080.00
Хуримтлагдсан ашиг	(13,507,934.71)	389,678,908.45
Эзэмшигчдийн өмчийн дүн	5,535,350,145.40	5,938,536,988.58
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	5,636,681,148.62	9,226,349,004.25

1.2 ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

№	Үзүүлэлт	2023 он	2024 он
		мян.төг	мян.төг
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,483,572,565.32	3,684,637,995.11
2	Нийт ашиг (алдагдал)	2,483,572,565.32	3,684,637,995.11
3	Түрээсийн орлого	53,056,059.99	82,681,820.29
4	Хүүний орлого	1,013,882.53	4,743,500.30
5	Бусад орлого	0.00	0.00
6	Удирдлагын зардал	0.00	00.1
7	Борлуулалт, маркетингийн зардал	1,875,787,256.95	2,847,992,923.08
8	Санхүүгийн зардал	0.00	48,235,429.77
9	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
10	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
11	Бусад зардал	26,704,012.73	107.864,623.40
12	Татвар төлөхийн өмнөх ашиг	635,141,238.16	767,970,339.47
13	Орлогын татварын зардал	66,148,525.08	87,583,496.29
14	Тайлант үеийн цэвэр ашиг	568,956,713.08	680,386,843.18

1.3 МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

№	Үзүүлэлт	2023 он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,102,675,297.84
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,098,315,174.84
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	4,360,123.00
	Буцаан авсан албан татвар	0.00
	Бусад мөнгөн орлого	0.00
1.2	Мөнгөн зарлага (-)	3,282,703,345.60
	Ажиллагчдад төлсөн	1,109,900,380.23
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	130,056,665.70
	Бараа материал худалдан авахад төлсөн	719,447,127.04
	Ашиглалтын зардалд төлсөн	138,808,534.51
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	407,146,350.66
	Хүүний төлбөрт төлсөн	88,654,985.28
	Татварын байгууллагад төлсөн	450,845,521.66
	Даатгалын төлбөрт төлсөн	11,131,000.00
	Бусад мөнгөн зарлага	231,712,780.52
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	819,971,952.24
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	34,752,092.82
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	30,008,592.52
	Хүлээн авсан хүүний орлого	4,743,500.30
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,071,882,301.26

	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	878,633,840.74
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	193,248,460.52
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,037,130,208.44
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,143,000,000.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	3,143,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,808,847,487.52
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	3,658,428.34
	Хувьцаа буцаан худалдаж авахад төөсөн	1,550,625,086.98
	Төлсөн ногдол ашиг	254,563,963.20
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,334,152,521.48
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,116,994,265.28
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	571,517,003.97
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,688,511,269.25

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 2. КОМПАНИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАГНАЛ

2025.03.17

Борхойн тал

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/	
<p>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</p>	
Тайлагнах хугацаа	2024 оны 01 дүгээр сарын 01-нээс 2024 оны 12 дугаар сарын 31
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Э-Транс ложистикс ХК, ETR, 99117631
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Ачаа тээвэр, гаалийн нэг цэгийн үйлчилгээ
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК, 2014 оны 09 дүгээр сарын 17
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	46,200,000 ширхэг
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Тайлан бэлтгэсэн: Дотоод ажил хариуцсан ажилтан С.Ганбат Хянасан: Гүйцэтгэх захирал Ч.Энхболд
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/


Санхүүгийн байдлын үзүүлэлт	<p>Эргэлтийн хөрөнгийн дүн – 4,297,803,527.83 Эргэлтийн бус хөрөнгийн дүн – 4,928,545,476.42 Нийт хөрөнгийн дүн – 9,226,349,004.25 Богино хугацаат өр төлбөрийн дүн – 148,470,444.01 Урт хугацаат өр төлбөрийн дүн – 3,139,341,571.66 Өр төлбөрийн нийт дүн – 3,287,812,015.67 Эзэмшигчдийн өмчийн дүн - 5,938,536,988.58 Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн – 9,226,349,004.25</p>
Орлогын тайлан	<p>Борлуулалтын орлого (цэвэр) – 3,684,637,955.11 Нийт ашиг (алдагдал) – 3,684,637,995.11 Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) – 767,970,339.47 Татварын дараах ашиг (алдагдал) – 680,386,843.18 Нийт орлогын дүн - 680,386,843.18</p>
Өмчийн өөрчлөлтийн тайлан	<p>Өмч - 4,620,000,000.13 Нэмж төлөгдсөн капитал - 154,000,000.00 Эздийн өмчийн бусад хэсэг - 774,858,080.00 Хуримтлагдсан ашиг – 389,678,908.45 Нийт дүн - 5,938,536,988.58</p>
Мөнгөн гүйлгээний тайлан	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ
	<p>Мөнгөн орлогын дүн (+) – 4,102,675,297.84 Мөнгөн зарлага (-) – 3,287,703,345.60 Цэвэр мөнгөн гүйлгээ – 819,971,952.24</p>
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ
	<p>Мөнгөн орлогын дүн (+) – 34,752,092.82 Мөнгөн зардагын дүн (-) – 1,071,882,301.26 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн - (1,037,130,208.44)</p>
	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

		Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлогийн дүн -	3,143,000,000.00
		Мөнгөн зарлагийн дүн -	1,808,847,478.52
		Бүх цэвэр мөнгөн гүйлгээ -	1,116,994,265.28
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл -	1,688,511,269.25
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт		
	Аудитын тайлан дуусаагүй байгаа тул Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх үед тайланг хэлэлцүүлэх болно.		
1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/		
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл		
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/		
	<p>2024 онд тус компанийн үйл ажиллагаа улс орны эдийн засгийн нөхцөл байдал сайжирч байгааг даган өмнөх жилүүдийн байдлаас сайжирч нэлээдгүй ажил үйлчилгээтэй, ашиг орлого нэмэгдсэн. Үндсэн үйл ажиллагаа болох төмөр замаар шилжүүлэн ачих үйл ажиллагаа зорилтот түвшинд хүрээгүй боловч шилжүүлэн ачилтын орлого өмнөх жилийн мөн үеийнхээс өссөн байна. Гаалийн хяналтын бүсэд нэвтэрч гаалийн бүрдүүлэлт хийсэн тээврийн хэрэгсэл өмнөх жилүүдийнхээс нэлээдгүй тоогоор ихссэн бөгөөд энэ нь тус гаалийн хяналтын бүс дэх өндөрлөсөн тавцанг ашиглан чингэлгээр орж ирсэн автомашиныг буулгах ажлыг гаалийн байгууллагатай хамтран зохион байгуулсны үр дүн юм. Энэхүү ажлын хүрээнд 3823 тээврийн хэрэгсэлээр оруулж ирсэн чингэлгийг задалж ойролцоогоор 15,200 автомашиныг буулгах ажлыг хийж гүйцэтгэжээ. Гаалийн хяналтын бүсэд өмнөх жилд 27039 тээврийн хэрэгсэл нэвтэрч байсан бол 2024 онд 38526 тээврийн хэрэгсэл нэвтэрч гаалийн хяналт шалгалтад хамрагдсан нь өмнөх жилүүдэд тус гаалийн хяналтын бүсэд орж ирж байгаагүй тоо хэмжээ юм.</p>		


д/д	Орлогын нэр	2023 он	2024 он	Зөрүү	Өсөлт бууралт
1	Ачилтын орлого	143,006.3	368,066.6	225,060.3	1,5 дахин өссөн
2	Хадгалалт болон гарах хуудас	1,771,509.3	1,787,745.0	16,235.7	0,9% өссөн
3	Түрээсийн орлого	53,046.1	82,682.0	29,635.9	55,8% өссөн
4	Бусад орлого	570,070.8	1,533,569.4	963,498.6	1,6 дахин өссөн

Компанийн үйл ажиллагааны хүрээнд өмнөх жилүүдтэй харьцуулсан зарим голлох үзүүлэлтүүдийг графикаар гаргаж үзүүлбэл:

Гаалийн хяналтын бүсэд нэвтэрсэн тээврийн хэрэгсэл



2012-2024 ОНЫ ШИЛЖҮҮЛЭН АЧИЛТЫН ТОО



2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт		
	Хөрөнгийн байдлын үнэлгээ		
	Төрөл	Үзүүлэлт	Дүгнэлт
		2024	Үндсэн хөрөнгийн өсөлтийн хурд нь 0.1 хувь байна.
	Хөрөнгийн өсөлтийн хурд	0.1	
	Эргэлтийн хөрөнгийн хувийн жин	47.14	Эргэлтийн хөрөнгийн эзлэх хувийн жин өмнөх оныхоос 2,8 дахин өссөн байна. Хөрөнгийн хөрвөх чадвар сайн Нийт хөрөнгийн 47.14 хувийг эзэлж байна
	Санхүүгийн байдлын үнэлгээ		
	Төрөл	Үзүүлэлт	Дүгнэлт
		2024	Ажлын капитал сайн ба ямар нэгэн өр төлбөрийн дарамтын эрсдэл бага байна. Ажлын цэвэр капитал нь компанийн хөрвөх чадварын чухал үзүүлэлт ба мөнгөн дүнгээр илэрхийлэгдэнэ. Өмнөх оныхоос 3,313,026,076.71 төгрөгөөр өссөн байна.
	Ажлын капитал	4,158,446,250.63	
	Ажлын капиталын оролцоо	0.95	Өр төлбөрийн дарамтад орох эрсдэл бага.Компанийн хөрвөх чадвар сайн байна.
	Эргэлтийн харьцаа	23.4	Эргэлтийн хөрөнгөөр богино хугацаат өр төлбөрийг барагдуулах чадвар сайн. Эргэлтийн харьцаа сайн.
	Өрийн харьцаа	2.77	Компанийн өр зээл бол ашиг нэмэгдүүлэх, ашиг олох зорилгоор ашиглаж байгаа хүмүүсийн мөнгө. Тиймээс зээл санхүүжилт авч үйл ажиллагааг өргөтгөх шаардлагатай. Нийт эх үүсвэрт зээлийн эх үүсвэрийн эзлэх хувийн жин юм.

2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл		
	2024 оны 10 сарын 16-ны өдөр тус компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Э-Транс ХХК-ийн хувьцаа эзэмшил 75 хувийг давсан тул 2024 оны 11 сарын 13-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлаар Компанийн тухай хуулийн 54.4 дэх заалтыг үндэслэн бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Уг хурлаар Э-Транс ХХК-нд хувьцаагаа худалдан авах зөвшөөрлийг олгож, хувьцаагаа эргүүлэн худалдаж авах хувьцааны үнийг 118.08 төгрөгөөр, хувьцаагаа худалдан авах саналын эхлэх өдрийг 2024 оны 11 сарын 18-ны өдрөөр, санал дуусах хугацааг 2024 оны 12 сарын 19-ний өдрийг дуустал байхаар тогтоосон. Энэхүү шийдвэрийн дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв болон Э-Транс ХХК-тай гурвалсан гэрээ байгуулан хувьцаагаа худалдах хүсэлт ирүүлсэн 3 хувьцаа эзэмшигчийн 66,414 ширхэг хувьцааг худалдан авч хувьцааны төлбөрийг шилжүүлэгдсэн байна.		
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Байхгүй	
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	2024 оны 08 сарын 12-нд компанийн үйл ажиллагааг өргөтгөж ашиг орлогыг нэмэгдүүлэх зорилгоор "Э-транс ложистикс" ХК-ийн барилгын ойролцоох нийтийн эзэмшлийн газрыг худалдан авах, засварлахад шаардлагатай ажлуудыг хийж гүйцэтгэх зорилгоор Худалдаа, хөгжлийн банкаас хөрөнгө оруулалтын зээл судлуулан 3 тэрбум төгрөгийн зээлийг авсан. Зээлийн барьцаанд компанийн үл хөдлөх эд хөрөнгө болох оффисын байр, уурын зуух, агуулахуудыг, газар эзэмших эрх зэргийг барьцаалсан байна. Зээлийн эргэн төлөлт хэвийн.	
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/		
	Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй.		
4.	Цалин урамшууллын мэдээлэл		

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь компаниас цалин урамшуулал авдаггүй болно. Тус компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс тухайн компанийн хувьцааг эзэмшдэг гишүүн байхгүй, санхүүгийн жилийн хугацаанд гүйцэтгэх захирал 38,456,000 төгрөгийн цалин урамшуулал авсан байна.

5. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр цахимаар зохион байгуулагдсан компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгосон.

д/д	Овог нэр	Албан тушаал	Хувьцаа эзэмшилт	Боловсрол	ТУЗ-ын хуралд оролцсон байдал	Ажлын туршлага
1.	Энхболдын Батболд	ТУЗ-ын дарга, хараат гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	100%	Баянцемент ХХК, Ерөнхий захирал
2.	Чулууны Энхболд	ТУЗ-ын хараат гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	100%	Э-Транс ХХК, Ерөнхий захирал
3.	Амарсанаагийн Бат-Орших	ТУЗ-ын хараат гишүүн	28,260ш 0,06%	Дээд	100%	Баянцемент ХХК, Үйл ажиллагаа хариуцсан дарга
4.	Бүрэнмэндийн Лхагвадорж	ТУЗ-ын хараат гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	75%	Би Ди Сек ХК, Гүйцэтгэх захирал
5.	Данзангийн Даянбилгүүн	ТУЗ-ын хараат гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	75%	Би Ди Сек ХК, Ерөнхийлөгч
6.	Одгийв Уранбайгаль	ТУЗ-ын хараат гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	75%	Би Ди Сек ХК, backoffice албаны менежер

7.	Халтарын Батхишиг	ТУЗ-ын хараат бус гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	60%	Нефть ойл ХХК, Захирал
8.	Жаргалсайханы Энхтулга	ТУЗ-ын хараат бус гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	100%	Лайф ис Гүүд Монголиа ХХК, нягтлан бодогч
9.	Чулуунбаатарын Оргил	ТУЗ-ын хараат бус гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	100%	МГТБУ ТӨХХК, гэрээний ахлах






ТУЗ-ын даргаар Э.Батболд, аудитын хороонд Ж.Энхтулга / дарга /, гишүүд Х.Батхишиг, Б.Лхагвадорж, нэр дэвшүүлэх хороонд Ч.Оргил / дарга /, гишүүд Ж.Энхтулга, А.Бат-Орших, цалин урамшууллын хороонд Х.Батхишиг / дарга /, гишүүдэд Ч.Оргил, Д.Даянбилгүүн нар сонгогдон ажиллаж байна.

Компанийн засаглалын хэрэгжилтийн үнэлгээний тайлан мэдээг гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржийн холбогдох хэлтэст хүргүүлж үнэлүүлсэн. Цаашид компанийн засаглалыг бэхжүүлэх кодексийн хэрэгжүүлэлтийг сайжруулах, шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

2024 оны 02 сард гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа нь хүнд өвчний улмаас нас барсан тул гүйцэтгэх захирлын үүргийг Ерөнхий нягтлан бодогч Э.Ариунтуяа түр орлон гүйцэтгэж байгаад 2024 оны 05 сарын 25-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн хурлаар Чулууны Энхболдыг гүйцэтгэх захирлаар томилж хөдөлмөрийн гэрээ байгуулсан.

д/д	Овог нэр	Албан тушаал	Боловсрол, мэргэжил	Ажлын туршлага
1.	Чулууны Энхболд	Гүйцэтгэх захирал	Дээд, инженер	Тус компанийг үүсгэн байгуулсан.
2.	Эрдэнэбаатар Ариунтуяа	Ерөнхий нягтлан бодогч	Дээд, математикч, нягтлан бодогч	2011 оноос хойш ажиллаж байна.
3.	Гомбо Оюунгэрэл	Гаалийн хяналтын талбайн эрхлэгч	Дээд, багш	2011 оноос хойш ажиллаж байна.
4.	Ванданлхүндэв Баасансүрэн	Ачаа тээврийн ахлах мэргэжилтэн	Дээд, Эрүүл ахуйч	2011 оноос хойш ажиллаж байна.
5.	Содномцэрэн Ганбат	Дотоод ажил хариуцсан ажилтан,	Дээд, хуульч цагдаагийн	2014 оноос хойш ажиллаж байна.

		ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	байгууллагын ажилтан	
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл			
	Тайлангийн хугацаанд ачаа барааг төмөр замаар шилжүүлэн ачих үйл ажиллагаа үндсэндээ зогссон. Цөөн тохиолдолд зарим төрлийн төмөр хийц төмөр замаар ачигдахаас бусад төрлийн ачаа ачигдахгүй болсон байна. Энэ нь автозамаар тээвэрлэлт хийгдэж байгаагаас шалтгаалахаас гадна УБТЗ-аас салбар замд вагон хуваарилахгүй монопол эрх эдэлж байгаагаас шалтгаалж манай компаниар вагон захиалуулан шилжүүлэн ачилт хийлгэх үйлчлүүлэгч ховордсон болно. Гаалийн хяналтын бүсийн хувьд Гаалийн байгууллагаас ачаа барааг ялгавартай хуваарилаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар хангалттай хэмжээнд ажиллаж байгаа болно.			
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/			
	Э-Транс ХХК / нийт хувьцааны 98,07% / нь 5%-иас дээш хувьцааг дангаараа эзэмшиж байгаа ба бусад жижиг хувьцаа эзэмшигчид 1,92% буюу 889,132 ширхэг хувьцааг эзэмшиж байна.			
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл			
	Төсөл хэрэгжүүлэхээр хувьцаа гаргаагүй болно.			
9.	Ногдол ашгийн мэдээлэл			
	2021 оны үйл ажиллагааны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 1 төгрөг байхаар тооцож 46,200,000 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд тараахаар шийдвэрлэн 2022 оны 12 сарын 31-ний дотор Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан нийт хувьцаа эзэмшигчдэд тараасан болно. 2023 оны 02 сарын 17-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн эчнээ хурлын шийдвэрээр компанийн 2022 оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 46 хувь буюу нэгж хувьцаанд 3 төгрөг байхаар тооцон 46,200,000 хувьцаанд нийт 138,600,000 төгрөгийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд тарааж 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдөр дансанд нь байршуулсан. 2024 оны 02 сарын 19-ний эчнээ хурлаас 2023 оны санхүүгийн үйл ажиллагааны татварын дараах цэвэр ашгаас нэгж хувьцаанд 6 төгрөг байхаар 277,200,000 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилахаар 01 тоот шийдвэр гарсныг Хөрөнгийн бирж болон цахим хуудсаар дамжуулан нийтэд хүргэж 2024 оны 11-р сард Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг тарааж дууссан байна. 2025 онд үйл ажиллагааг сайжруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник тоног төхөөрөмж шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэхээр			

	төлөвлөсөн тул 2025 оны 02 сарын 11-ний өдрийн 01 тоот Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор хувьцаа эзэмшигч нэрт ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.	
10.	Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл	
	Тус компани нийгмийн хариуцлагын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд: Компаниас тэтгэвэртээ гарсан ахмадын бүртгэлд байдаг 6 ажилтанд сар шинийн баяраар гарын бэлэг хүргүүлсэн. Дотоод журамд заагдсаны дагуу 4 ажилтны ар гэрт гачигдал гарсан учир зохих тусламж тэтгэмжийг олгосон. Мөн 2 ажилтны гэр бүлд бүл нэмсэн, 1 ажилтны хүүхдийн даахь үргээх арга хэмжээ зохион байгуулагдсан тул дотоод журмын дагуу тэтгэмжийг олгосон байна. 2024 онд нийт ажилчид ажлын өндөр амжилт гаргасан тул удирдлагын зүгээс БНХАУ-ын Хайнань мужийн Хайкоу, Саня хот, Өвөрмонголын өөртөө засах орны төв Хөх хотуудад 8 хоногийн аялалд явуулж амраасан.	
	Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	
	Овог, нэр: Чулуун овогтой Энхболд Албан тушаал: "Э-Транс ложистикс" ХК-ийн гүйцэтгэх захирал Гарын үсэг:  (Тамга/тэмдэг) 	Овог, нэр: Содном овогтой Тунгалаг Албан тушаал: "Их Монгол хөлөг аудит" ХХК аудитын компанийн захирал Гарын үсэг:  (Тамга/тэмдэг) 
	Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	
	Овог, нэр: Содномцэрэн овогтой Ганбат Албан тушаал: Дотоод ажил, хяналт хариуцсан ажилтан Гарын үсэг: 	

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 3. КОМПАНИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТ

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТ

2025.03.15

Улаанбаатар хот

Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар хэлэлцэж дараах дүгнэлт гаргасныг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна.

Э-Транс ложистикс ХК-ны 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлагналд дурдсанаар тус компани нь санхүүгийн жилд 631,807,705.27 төгрөгийн үйл ажиллагааны орлоготой ажиллаж өмнөх жилийнхээс тодорхой хэмжээгээр өссөн, нэлээдгүй үр ашигтай ажилласан байна.

2024 оны үйл ажиллагаанд үнэлэлт өгөн компанийн үндсэн үйл ажиллагаа болох төмөр замаар ачаа, бараа шилжүүлэн ачих үйл ажиллагаанд голлох байр суурь эзлэх болсон төмөр хийцийн шилжүүлэн ачилтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд төмөр хийцийн гаалийн бүрдүүлэлтийг өөрийн хяналтын бүсэд хуваарилуулан шилжүүлэн ачилтыг нэг дор зохион байгуулах боломжийг судлан хэрэгжүүлэхээр үүрэг өгөгдсөн боловч энэхүү чиглэлд хяналт тавьж байгаа гаалийн байгууллагаас баталсан хуваарийнхаа дагуу ачаа барааг хуваарилах шаардлагатай гэсний үүднээс энэхүү ажил амжилтгүй болжээ. Гэхдээ өмнөх жилүүдэд гэрээ байгуулсан зарим аж ахуйн нэгжүүд гэрээний үндсэн дээр тус гаалийн хяналтын бүсэд хяналт шалгалтаа хийлгэн вагонд шилжүүлэн ачилт хийсэн ба энэ онд 215 вагон шилжүүлэн ачжээ. Шилжүүлэн ачилтын үйл ажиллагааг хэвийн явуулахад гол бэрхшээлтэй байгаа зүйл нь вагон хуваарилах асуудал хэвээр байгааг үйл ажиллагааны тайланд дурдсан байна.

Үндсэн үйл ажиллагаа доголдолтой байгаа боловч гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр гаалийн байгууллагатай хамтран ажилласны үр дүнд компанийн ачаа бараа шалгах зориулалт бүхий өндөрлөсөн тавцанг ашиглан тээврийн хэрэгсэл дээр ачигдаж ирсэн чингэлгийг задлаж буулгах ажлыг хийж хэрэгжүүлснээр тус гаалийн хяналтын бүсэд нэвтэрсэн тээврийн хэрэгсэл 38,526 болж өссөн бөгөөд гарах хуудасны орлого 1,628,064,156 төгрөг болж нэмэгдсэн байна. Өндөрлөсөн тавцан ашиглаж чингэлэг задалж буулгах үйлчилгээг өмнөх жилүүдэд туршиж байсныг ажил хэрэг болгон үйлчилгээг нэмэгдүүлснээр 2024 онд 3826 чингэлэг задалж 15,300 орчим тээврийн хэрэгслийг буулган үйлчлүүлэгч нарт нь ямар нэгэн асуудалгүй хүлээлгэн өгсөн нь үйлчлүүлэгч болон гаалийн байгууллагад үнэлэгдэхүйц ажил болж цаашид үргэлжлүүлэн хийгдэхээр төлөвлөгджээ.

Гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаа ийнхүү жил тутам нэмэгдэж байгаагаас шалтгаалан гаалийн хяналтын бүсийн зай талбайн багтаамжийг нэмэх шаардлага гарсныг холбогдох иргэн, төр захиргааны байгууллагатай хамтран шийдвэрлэхээр ажиллаж эхний ээлжид хувь иргэнд байсан газрыг худалдан авч үлдсэн газрыг авах талаар ажил зохион байгуулж байгаа нь дүгнэлтэд дурдахуйц ажил болсон байна.

Гүйцэтгэх удирдлагаас 2024 оны бизнес төлөвлөгөөнд заагдсан гаалийн хяналтын бүсийг цахимжуулах ажлыг Монгол улсын Ерөнхий сайдаас гаалийн байгууллага, боомтын захиргаанд өгөгдсөн үүрэгтэй уялдуулан ухаалаг орц гарцын төхөөрөмжийг худалдан авах ажилд 24 сая төгрөгийг зарцуулсан байх бөгөөд цаашид энэхүү ухаалаг төхөөрөмжийн программ хангамжийг өөрийн үйл ажиллагаа болон гаалийн байгууллагатай холбох ажлыг хийж дуусгахаар ажиллаж байгаатай танилцсан бөгөөд энэ нь үйл ажиллагаагаа хөнгөвчилсөн үйлчлүүлэгч иргэдэд хүрсэн ажил болжээ.

Гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаа ингэж өргөжихийн хэрээр гаалийн хяналтын бүсэд ачаа бараа хадгалсан үйлчилгээ болон бусад үйлчилгээ дагаж өссөн байх бөгөөд бусад орлого өмнөх оны мөн үеийнхээс 1,6 дахин өсөж 1,533,569.4 төгрөгийн ашиг олсон байна.

Өмнөх жилүүдэд гаалийн нэг цэгийн үйлчилгээний танхим болон 2 давхрын гаалийн байцаагч нарын танхим бусад өрөө тасалгааг үе шаттайгаар засварлаж дуусгасан байх бөгөөд 2024 онд төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 3 давхрын өрөөнүүдийн засварын ажлыг хийж гүйцэтгэн нийт 117 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Компани нь 2024 онд үйл ажиллагааг өргөтгөж ашиг орлогыг нэмэгдүүлэх зорилгоор компанийн барилгын ойролцоох нийтийн эзэмшлийн газрыг худалдан авах, засварлах, “Э-транс ложистикс” ХК-ийн хувьцааг худалдан авахаар зорилгоор Худалдаа, хөгжлийн банкнаас 3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл, шинээр тээврийн хэрэгсэл худалдан авахад зориулж 143 сая төгрөгийн зээл зэргийг авсан байх бөгөөд зээлийн зарцуулалт, эргэн төлөлт хэвийн байна. Цаашид зээлийн эргэн төлөлт, зарцуулалтад онцгой анхаарал тавихыг гүйцэтгэх удирдлагад даалгалаа.

Ажилчдын ажиллах идэвх сонирхлыг дэмжих, ажлын бүтээмжийг сайжруулах, урамшуулах үүднээс нийт ажилчдаа БНХАУ-ын Хайнань мужийн Саньяа амралт жуулчлалын бүс, Өвөрмонголын Хөх хотуудаар 8 хоногийн аялал хийж амруулсан нь сайшаалтай ажил болсон байна.

2025 онд өмнөх оныхоо ажлыг баталгаажуулан үр ашгаа бууруулахгүй байхад анхаарч ажиллахын зэрэгцээ дараах ажлуудад анхаарлаа хандуулж ажиллана уу

1. Компанийн эзэмшиж болох газрыг худалдан авах, тэдгээрийг тохижуулах ажилд анхаарч ажиллах,
2. Шилжүүлэн ачилтыг нэмэгдүүлэх, өөр төрлийн үйлчилгээг салбар замаа ашиглан зохион байгуулах боломжийг судлах,
3. Зээлийн зарцуулалт, эргэн төлөлтөд анхаарах,
4. “БиДиСек ҮЦК” ХК-тай хамтран хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох ажлыг зохион байгуулах,

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 4. КОМПАНИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ



Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025.02.15

Борхойн тал

д/д	Үндсэн үйл ажиллагаа	Хийгдэх ажил	Салбар ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
1	1. Үндсэн ажлын хүрээнд	1.1 Хяналт, зохион байгуулалтын арга хэмжээ	Компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай болон бусад шаардлагатай асуудлаар гүйцэтгэх удирдлагын баг тухай бүр хуралдаж тодорхой шийдвэрүүдийг гаргах,	2025 онд	Гүйцэтгэх удирдлага	Компанийн үйл ажиллагаа сайжирч цаашид авч хэрэгжүүлэх ажлууд төлөвлөгдөнө.
2			Үйл ажиллагаандаа заавал мөрдөж ажиллахаар заагдсан удирдлагын баримт бичгийг ажилчдаас дагаж мөрдөж байгаа байдалд байнгын хяналт тавьж ажиллах,	2025 онд	Гүйцэтгэх удирдлага	Ажилчдын сахилга хариуцлага сайжирна.
3			Компанийн ажилчид ажил үүргээ гүйцэтгэхдээ холбогдох дүрэм, журам, ажлын цаг ашиглалт зөрчиж байгаа эсэхэд дотоод хяналт шалгалтыг хуваарийн дагуу зохион байгуулах,	2025 онд	Дотоод хяналт шалгалтын нэгж	Ажилчдын ажлын цаг ашиглалт алдагдах, дүрэм журам зөрчигдөхөөс сэргийлнэ.
4			Ажилчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулахдаа ажлын байрны тодорхойлолтонд заагдсан ажил үйлчилгээг үр дүнтэй, чанартай хийж гүйцэтгэх талаар заавар зөвлөгөө өгч ажиллах,	2025 онд	Гүйцэтгэх удирдлага	Ажилчдын хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүрэг, ажлын байрны тодорхойлолтын чиглэл тодорхой болно.
5			Ажилчид болон гүйцэтгэх удирдлагын баг нь өөрийн үйл ажиллагаа, харилцааны асуудалд онцгой анхаарч ажиллах ба Компанийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөж ажиллах,	2025 онд	Нийт ажилчид	Ажилчдын харилцааны соёл дээшилж, удирдлага болон ажилчдын хоорондох ёс зүйн харилцаа дээшилнэ.
6		1.2 Вагон ачилтыг нэмэгдүүлэх, үндсэн үйл ажиллагааг сайжруулах	2024 онд төлөвлөгдөөд хийгдэж дуусаагүй ажлууд болох компанийн үйл ажиллагааг сайжруулах менежментийн цогц бодлого боловсруулах, бизнес төлөвлөгөөг гарган батлуулан, мөрдөж ажиллах,	2025 оны хагас жилд	Гүйцэтгэх удирдлага	Компанийн менежемент сайжирч, цаашид хийгдэх ажлууд төлөвлөгдөнө.
7			Төмөр замтай байгуулах гэрээ, хэлцлүүдийг байгуулах, хугацаа дуусмагц сунгах, гэрээний дүнг хэлэлцэх,	2025 оны 1-р сард	Ачаа тээврийн алба	Төмөр замын байгууллагатай хамтран ажиллах ажлын үр дүн дээшилнэ.
8			Ачилтын төлөвлөгөөний дагуу ачааг ачих боломжийг судлан үйлчлүүлэгч татах ажлыг оновтой хэлбэрээр зохион байгуулах,	2025 онд	Ачаа тээврийн алба	Ачилтыг сайтар төлөвлөснөөр үйлчлүүлэгчийг татах ажилд ахиц гарна.
9			Вагон ашиглалтын хугацааг багасгах, пүүлэгч нарын ажлын идэвх санаачилгыг дээшлүүлэх, тэднийг байнгын удирдлагаар хангах,	2025 онд	Ачаа тээврийн алба	Пүүлэгч нарын ажлын хариуцлага сайжирч, вагон ашиглалтын хугацаа багасна.

10	1.3 Гаалийн хяналтын бүс, баталгаат агуулахын үйл ажиллагааг зохион байгуулах	Гаалийн хяналтын бүс, баталгаат агуулахын өнгө үзэмж, эмх цэгцийг байнга шалгаж шаардлагатай ажлуудыг танилцуулан хийж ажиллах,	2025 онд	Г.Оюунгэрэл	Гаалийн хяналтын бүс, баталгаат агуулахын эмх цэгц, үйл ажиллагаа сайжирна.	
11		Гаалийн баталгаат агуулахыг шинэчлэн засварлахтай холбоотой хийгдэх ажлыг төлөвлөн удирдлагад танилцуулах,	2025 онд	Г.Оюунгэрэл	Үйлчилгээний нэр төрлийг олшруулах боломж нөхцлийг бүрдүүлнэ.	
12		Гаалийн хяналтын бүсэд нэвтэрсэн, баталгаат агуулахад хадгалагдаж байгаа тээврийн хэрэгсэл, ачаа барааны тайланг сар, улирал, жилээр гарган холбогдох газар, компанийн эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж байх,	2025 онд	Г.Оюунгэрэл	Хяналт шалгалт сайжирна.	
13		Гаалийн хяналтын бүс, баталгаат агуулахын харуул хамгаалалтын албаны өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж үүрэг чиглэл өгч ажиллах,	2025 онд	Г.Оюунгэрэл С.Ганбат		
14		Хяналтын бүсийн зам талбайг засварлах тэгшлэх, ус тогтоохгүй байх ажил зохион байгуулах,	2025 онд	Г.Оюунгэрэл Гүйцэтгэх удирдлага	Үйлчлүүлэгч, түрээслэгч нарт аюул осолгүй ажиллах таатай нөхцөл бүрдэнэ.	
15		1.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг сайжруулах, ажилтны аюулгүй ажиллах нөхцлийг хангах, тэдний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх,	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг сайжруулах чиглэлээр сургалтыг улирал бүр зохион байгуулах, мэргэжлийн байгууллагаас сургагч багш урьж авчран ажилчдыг сургалтанд хамруулж байх,	2025 онд	ХАБЭА ажилтан	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаар тогтоосон дүрэм журмын хэрэгжилт сайжирч үйлдвэрлэлийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлнэ.
16	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгыг тогтоосон хугацаанд өгч өгсөн зааварчилгыг ажилтны хувийн хэрэгт хавсаргаж байх,		2025 онд	ХАБЭА ажилтан		
17	Хөдөлмөр хамгаалалын хувцас хэрэгслийн бүрэн бүтэн байдал, эдэлгээний норм хугацаа дууссан эсэхийг ажилтан нэг бүрийхийг үзэн шалган гүйцэтгэх удирдлагад танилцуулан шаардлагатай хувцас хэрэгслийг нөхөж авах, хувцас хэрэгслийг картлан ажилтанд тавьж олгох,		2025 оны 1-р улиралд	ХАБЭА ажилтан, нярав		
18	Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн дүрэм журам зөрчигдөж байгаа эсэхэд байнгын үзлэг шалгалт зохион байгуулах,		Сард 2 удаа	Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн зөвлөл		
19	Аюулыг мэдэгдэх хуудасны ашиглалтыг нэмэгдүүлэх, ажилтан бүрт энэ талаар үүрэг даалгаврыг ХАБЭАхуйн зааварчилгын хамт өгөх,		2025 онд	ХАБЭА ажилтан		
20	2. Дотоод ажил	2.1 Засвар үйлчилгээ, тохиолтын ажил	Гадна талд хашаа, хаалт, ухаалаг орц гарцын тоног төхөөрөмжийг байрлуулах	2025 оны 4-6 сард	Механик цех	Ажлын чанар бүтээмж дээшилнэ.
21			Гаалийн хяналтын бүсэд нийтийн бие засах газрыг шинээр барих,	2025 оны 4 сард	Механик цех	Үйлчлүүлэгчдийн ая тухтай байдал хангагдана.
22			Офиссын үүдний машины ил зогсоолын талбайг асфальтлах, түүнийг тойрсон хашаа, орох гарах хэсэг дэх хаалтуудын ажлыг хийх,	2025 оны 4-6 сард	Гүйцэтгэх удирдлага	Үйлчилгээний хүрээ өргөжиж гадна орчны тохиолт сайжирна.
23			Харуулын 2-р байрыг шинэчлэн засварлах ажлыг хийж гүйцэтгэх,	2025 оны 4 сард	Харуулын алба	Ажилчдын ая тухтай ажиллах нөхцөл бүрдэнэ.
24			Машин тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэн үзлэг, тооллогод хамруулах,	2025 онд	Механик цех	Машин техникийн бүрэн бүтэн байдал сайжирна.

25			Өдөр тутам болон байнга хийгдэх засвар, үйлчилгээний ажлуудыг тогтоосон цагт, өгсөн нарядын дагуу хийж байгаад байнгын хяналт тавьж ажиллах,	2025 онд	Механик цех	Ажилчдын өдөр тутмын ажлын бүтээмж сайжирна.
26		2.2Техник технологийн шинэчлэлт	Үйлчилгээний нэр төрлийг олшруулахтай холбоотой техник технологийн шинэчлэл хийх боломж, хөрөнгийн судалгааг хийж Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах,	2025 оны 2-р улиралд	Ч.Энхболд Э.Ариунтуяа	Үйлчилгээний нэр төрлийг олшруулах ажилд ахиц гарна.
27	3. Сургалт, нийгмийн хамгаалал	3.1 Сургалт соён гэгээрүүлэх ажил	Ажилтан нарт шаардлагатай сэдвүүдийн дагуу бусад байгуулагуудаас сургагч урьж сургалт явуулах,	2025 онд	Э.Ариунтуяа	Ажилчдын ажлын мэдлэг туршлага дээшилнэ.
28			Ажилчдын эв нэгдлийг хангах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд зориулж тодорхой төрлийн урлаг спортын арга хэмжээнүүдийг тухай бүр зохион байгуулах,	2025 оны улирал бүр	Зохион байгуулахаар томилогдсон комисс	Чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлнэ
29		3.2 Нийгмийн хамгаалал	Ажилчдыг компанид тогтвор суурьшилтай, идэвхитэй ажиллахад нөлөөлөхүйц компанийн дотоод журамд заагдсан нийгмийн хамгаалалын тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэх,	2025 онд	Ч.Энхболд Э.Ариунтуяа	Нийгмийн хамгаалал сайжирна.
30			Шинээр хийгдэх бүтээн байгуулалтын ажлуудын хүрээнд хийгдэх ногоон байгууламжийн ажлуудыг хийж гүйцэтгэх,	2019 онд	Нийт ажилчид	Байгууллагын өнгө үзэмж нэмэгдэнэ.
31			Үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн төр захиргааны байгууллагатай хамтран нийгмийн хамгаалалын тодорхой ажлыг хийж гүйцэтгэх,	2025 онд	Гүйцэтгэх удирдлага	Орон нутагтай харилцах харилцанд ахиц гарна.
32	4. Төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчдийн хурал	4.1 Хурлын бэлтгэл ажлыг хангах	Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, зөвлөлийн дэргэдэх хорооны хуралд бэлтгэх, гишүүдэд шаардлагатай мэдээллүүдийг цаг тухай бүрт хүргэх,	2025 онд	С.Ганбат	Компанийн засаглал сайжирна.
33			Компанийн жилийн ба хагас жилийн үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөг бусад албадаас ирүүлсэн саналын дагуу гаргаж Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулах,	2025 онд	С.Ганбат	
34			Компанийн засаглалын бодлогыг хэрэгжүүлж нийтэд ил болгох мэдээллүүдийг компанийн албан ёсны вэб хуудас, хөрөнгийн бирж, компанийн засаглалын сайтуудад тухай бүр тавьж хувьцаа эзэмшигч нарыг компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр бүрэн хангах,	2025 онд	С.Ганбат	
35			Хувьцаа эзэмшигчдийн хуралд шаардлагатай бичиг баримтыг цаг тухайд нь бэлэн болгох, хурал хуралдах ажлыг хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэгч компанитай хамтран зохион байгуулах,	2025 оны 2-р улиралд	С.Ганбат	
Нийт 4 бүлэг, 9 хэсэг, 35 ажил төлөвлөв.						

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН: ДОТООД АЖИЛ
ХЯНАЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН  С.ГАНБАТ

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 5. ТУЗ-ИЙН 2025 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

2025 оны ТУЗ-ын зардлын төсөв

	Зардлын нэр	Нэгжийн зардал	Зардлын дүн / төгрөг /
1	ТУЗ-ын гишүүдийн цалин	-	-
2	ТУЗ-ын нарийн бичгийн цалин	792,000*4	3,168,000
3	Зөвлөх үйлчилгээний хөлс	3,000,000	3,000,000
4	ТУЗ-ын хурлын зардал	100,000	100,000
5	Бичиг хэргийн зардал	1,000,000	1,000,000
6	Бусад / ХЭХ-ын зар гаргах /	500,000	500,000
	Дүн		7,768,000

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 6. ТУЗ-ИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

“Э-Транс Ложистикс” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Чулууны Энхболдын тодорхойлолт



1. Товч танилцуулга

Овог нэр: Чулууны Энхболд

Төрсөн он: 1967 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: Э-Транс ХХК-ийн ерөнхий захирал

2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Төв аймгийн Зуунмод хотын 10 жилийн сургууль	Бүрэн дунд	1974	1984
2	Ленинградын Төмөр замын дээд сургууль		1984	1989
3	АНУ-д агаарын тээврийн аюултай ачаа тээвэрлэлтийн сургалт		1999	2000

3. Ажлын туршлага

1989-1990 онд УБТЗ-ын өртөө ажилчин

1990-1992 онд УБТЗ-ын Замын –Үүд өртөө орлогч дарга

1992-1994 онд УБТЗ-ын Багануур өртөө орлогч дарга

1992-1997 онд ТУУШИН ХХК ОУ-ын тээвэр зууч, экспортын тээвэрлэлтийн мэргэжилтэн

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч
Амарсанаагийн Бат-Оршихын тодорхойлолт**

1. Товч танилцуулга

Овог нэр: Амарсанаагийн Бат-Орших

Төрсөн он: 1991 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: Баянцемент ХХК, Үйл ажиллагаа хариуцсан
дарга



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын 84-р дунд сургууль	Бүрэн дунд	1998	2008
2	Тайвань, Фү-Рен их сургууль	Бакалавр-Эдийн засагч	2011	2015
3	Монгол улсын их сургууль	Магистр-Улс төр судлал	2015	2016
4	Мандах их сургууль	Бакалавр-Нягтлан бодогч	2016	2018

3. Ажлын туршлага

2015-2016 онд Улаанбаатар хотын банк, Харилцагчийн менежер

2017-2018 онд Баянцемент ХХК, хангамжийн ажилтан

2018-2021 онд Баянцемент ХХК, Нягтлан бодогч

2022-2023 онд Баянцемент ХХК, Ерөнхий нягтлан бодогч

2023-оноос Баянцемент ХХК, Үйл ажиллагаа хариуцсан дарга

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч
Энхболдын Батболдын тодорхойлолт**

1. Товч танилцуулга

Овог нэр: Энхболдын Батболд

Төрсөн он: 1987 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: Э-Транс ХХК, дэд захирал



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1995	2004
2	Тайваний их сургууль	Эрх зүйч	2008	2014

3. Ажлын туршлага

2014 онд Тайвань дахь худалдаа эдийн засгийн төлөөлөгчийн газарт туслах ажилтан,

2016 оны 04 сараас Баянцемент ХХК, ерөнхий менежер

2018 оны 06 сараас Э-Транс ХХК, дэд захирал

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч
Эрдэнэбаатарын Ариунтуяагийн тодорхойлолт**



1. Товч танилцуулга

Овог нэр: Эрдэнэбаатарын Ариунтуяа
Төрсөн он: 1985 он
Иргэний харьяалал: Монгол
Эрхэлж байгаа ажил: “ Э-Транс ложистикс “ ХК-ны Ерөнхий
нягтлан бодогч

2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1993	2003
2	МУИС-ын МКСургууль	Эрсдэлийн эдийн засагч	2003	2007
3	Мандах бүртгэл дээд сургууль	Нягтлан бодогч	2009	2011
4	Шихихутаг хууль зүйн сургууль	Эрх зүйч	2023	

3. Ажлын туршлага

2008-2011 онд Төв аймгийн Цагдаагийн газарт тооцооны нягтлан бодогч
2011 оноос өнөөдрийг хүртэл Э-Транс ложистикс ХК-нд нягтлан бодогч, ерөнхий
нягтлан бодогчоор ажиллаж байна.

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч
Энхболдын Уянгын тодорхойлолт**



1. Товч танилцуулга

Овог нэр: Энхболдын Уянга
Төрсөн он: Төв аймаг
Иргэний харьяалал: Монгол
Эрхэлж байгаа ажил: Э-Транс ХХК нягтлан бодогч

2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1996	2006
2	Swansea University	инженер	2010	2013
3	ШУТИС	Инженер	2014	2016
4	Мандах Их сургууль	Нягтлан бодогч	2019	2021

3. Ажлын туршлага

2013 оноос Э-Транс ХХК нягтлан бодогч

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч
Амарсанаагийн Гэрэлцогтын тодорхойлолт**



1. Товч танилцуулга

Овог нэр: Амарсанаагийн Гэрэлцогт

Төрсөн он: Төв аймаг Баян сум

Иргэний харьяалал: Монгол улс

Эрхэлж байгаа ажил: “ Баянцемент ” ХХК Уулын инженер

2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1996	2006
2	ШУТИС-ийн УУИСургууль	Уурхайн ашиглалтын инженер	2007	2012

3. Ажлын туршлага

2012-2019 онд Э-Транс ХХК-нд уулын мастер

2019-өөс одоог хүртэл “ Баянцемент ХХК ”-нд уулын инженерээр ажиллаж байна

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч
Жаргалсайханы Энхтулгын тодорхойлолт**

1. Товч танилцуулга

Овог нэр: Жаргалсайханы Энхтулга
Төрсөн он: 1987 он
Иргэний харьяалал: Монгол
Эрхэлж байгаа ажил: “ Лайф ис гүүд монголиа ” ХХК,
нягтлан бодогч



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын 1-р сургууль	Бүрэн дунд	1995	2005
2	Санхүү Эдийн Засгийн дээд сургууль	Бизнесийн удирдлага	2005	2010

3. Ажлын туршлага

2011 онд МҮХАҮТанхим, НБТЗГазар туслах ажилтан,
2014-2015 онд “ Лайф ис гүүд монголиа ” ХХК, худалдан авалтын зөвлөх,
2015-2017 онд “ Лайф ис гүүд монголиа ” ХХК, гүйцэтгэх захирал,
2017 оноос “ Лайф ис гүүд монголиа ” ХХК, нягтлан бодогч

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч
Шатарын Мөнхбаатарын тодорхойлолт**



1. Товч танилцуулга

Овог нэр: Шатарын Мөнхбаатар

Төрсөн он: 1996 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: “Баянцемент” үйлдвэрийн дарга

2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд		
2	Эрдэм Их дээд сургууль	Барилгын инженер	2019	2022

3. Ажлын туршлага

2016-2019 онд “МАК” цемент үйлдвэрт ээлжийн мастер,

2020-2023 онд “Ховд-Эко” цементийн үйлдвэрт үйлдвэрийн диспетчр,

2023 оноос “Баянцемент” шохойн үйлдвэрт үйлдвэрийн дарга

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч
Чулуунбаатарын Оргилын тодорхойлолт**

1. Товч танилцуулга

Овог нэр: Чулуунбаатарын Оргил
Төрсөн он: 1987 он
Иргэний харьяалал: Монгол
Эрхэлж байгаа ажил:



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын 1-р сургууль	Бүрэн дунд	1995	2005
2	Хан-Уул Дээд сургууль	Бизнесийн удирдлага	2005	2010
3	Хан-Уул Дээд сургууль	Программ хангамж	2005	2011
4	Chinese Culture University	Мэдээллийн удирдлагын систем, Магистр	2012	2013

3. Ажлын туршлага

2015-2016 онд ҮАБЗөвлөл-ССХ-д мэргэжилтэн,
2017-2019 онд БНЭУлсын Элчин сайдын яам маркетингийн албаны дарга
2019 оноос Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК, гэрээний ахлах

ТАНИЛЦУУЛАХ АСУУДАЛ 7. НОГДОЛ АШГИЙН ТАЛААР ГАРГАСАН ТУЗ-ИЙН ШИЙДВЭР



Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025. 02. 11.

№ 01

Борхойн тал

Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай

Компанийн тухай Монгол улсын хуулийн 46-р зүйлийн 46.1, 46.5, 46.14 дэх заалт, Компанийн дүрмийн 3-р зүйлийн 3.19.9 дэх заалт, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс эчнээ санал хураалтаар авсан саналын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “ Э-Транс Ложистикс “ ХК-ны үйл ажиллагааг сайжруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник тоног төхөөрөмж шинэчлэх ажлыг 2025 онд хийхээр төлөвлөсөн тул 2024 оны үйл ажиллагааны орлогоос ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.

2. Ногдол ашиг хуваарилахгүй байх үндэслэлийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнахыг Гүйцэтгэх захирал / Ч. Энхболд /-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Э.БАТБОЛД

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААС ГАРГАХ ШИЙДВЭРИЙН ТӨСЛҮҮД

Төсөл

“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025.04.29

№01

Борхойн тал

Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Э-Транс Ложистикс” Хувьцаат Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг баталсугай.

Хурлын дарга:/

/

“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025.04.29

№02

Борхойн тал

**Компанийн үйл ажиллагааны
тайланг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь**:

1. “Э-Транс Ложистикс” Хувьцаат Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлөөс үйл ажиллагааны талаар гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал Ч.Энхболд-д даалгасугай.

Хурлын дарга:/

/

“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025.04.29

№03

Борхойн тал

**Компанийн 2024 оны үйл ажиллагааны
тайлан, санхүүгийн тайлангийн талаар
ТУЗ-ын дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь**:

1. “Э-Транс Ложистикс” Хувьцаат Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ын дүгнэлтийг хангалттай гэж үзсүгэй.
2. Үйл ажиллагааны төлөвлөгөө, гаргасан зөвлөмжийн гүйцэтгэлд анхаарч ажиллахыг Гүйцэтгэх захирал Ч.Энхболд-д даалгасугай.

Хурлын дарга:/ /

“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025.04.29

№04

Борхойн тал

**Компанийн 2025 оны үйл ажиллагааны
төлөвлөгөөг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс ложистикс” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсугай.
2. Төлөвлөгөөнд дурьдагдсан ажлуудыг чанартай хийж гүйцэтгэх, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал / Ч.Энхболд /-д даалгасугай.

Хурлын дарга:/ /

“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025.04.29

№05

Борхойн тал

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
зардлын төсөв батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтыг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс ложистикс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг 7,768,000 төгрөгөөр тогтоосугай.

Хурлын дарга:/ /

“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025.04.29

№06

Борхойн тал

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дах заалтыг удирдлага болгон Тооллогын комиссын дүн, тогтоолыг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс ложистикс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат гишүүдээр

- 1)
- 2)
- 3)
- 4)
- 5)
- 6)

2. “Э-Транс ложистикс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр

- 1)
- 2)
- 3) нарыг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр сонгогдсоныг баталсугай.

Хурлын дарга:/ /

